



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/151.

Чингис хот

Зочид, төлөөлөгчдийн албан
айлчлалд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймаг орон нутагт төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, хөрөнгө оруулах, гадаад хамтын ажиллагаа, харилцаагаа идэвхжүүлэх зорилгоор Монгол Улс дахь Америкийн нэгдсэн улсын элчин сайдын яам, Япон улсын элчин сайдын яамны элчин сайд, ажлын албаныхны хамт албан айлчлал хийсэнтэй холбогдуулан 1668000 /нэг сая зургаан зуун жаран найман мянган/ төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

20200318

Аймгийн Засаг даргын 2020 оны
...03... дугаар сарын ...13... өдрийн А/15/...
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Нэрс	Нэгжийн үнэ	Нийт хэрэглэгдэх тоо	Нийт үнэ
1	Хүлээн авалт	35600	36	1281600
2	Дурсгалын зүйл	Дурсгалын зүйлс, брэндийн бэлэг		386400
	Нийт үнэ			1 668 000